

ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, ЭРГҮҮЛЭН АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү журмын зорилго нь иргэн, айл өрх, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлын ангилал, хог хаягдлаа анхан шатанд ангилан ялгах, ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН АНГИЛАЛ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

1.1. “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий этгээд” хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зөвшөөрөлтэй, иргэн, аж ахуйн нэгжийг хэлнэ.

1.2. “Эх үүсвэр дээр ангилах” гэдэг нь хог хаягдлыг үүсгэгч этгээд дахин ашиглах боломжтой болон бусад хог хаягдал, ахуйн аюултай хог хаягдал, барилгын хог хаягдал, эмнэлгийн хог хаягдал гэж энэхүү журамд заасны дагуу ангилан хаяхыг хэлнэ.

1.3. “Дахин ашиглагдах боломжтой хог хаягдал”-д дараах хог хаягдлыг оруулна

- Цаас /сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, техникийн тос тосолгооны материалын хуванцар сав/
- Хөнгөн цагаан, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйлс
- Шил /хүнсний болон ундааны төрөл бүрийн шилэн сав/
- Модон эдлэлийн хаягдал
- Гялгар уут, хуванцар сав баглаа боодол

1.4. “Бусад хог хаягдал” гэж аливаа хогноос дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хэсгийг зайлуулахад үлдсэн ахуйн хог хаягдлын хэсгийг хэлнэ. “Бусад хог хаягдал”-д аюултай хог хаягдал, барилгын хог хаягдал, цахилгаан барааны хаягдал ба эмнэлгийн хог хаягдал орохгүй болно. “Бусад хог хаягдал”-д дараах хог хаягдлыг оруулна. Үүнд:

- Нүүрс, модны үнс
- Түргэн муудах хоол, хүнсний хаягдал
- Ариун цэврийн хэрэглэлийн хаягдал
- Дахин ашиглагдах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдал

1.5. “Аюултай хог хаягдал”гэдэг нь нийтийн эрүүл мэнд,хүрээлэн буй орчинд аюулчруулж буй болон учруулах боломжтой хог хаягдлыг хэлнэ. Үүнд:

- Будаг, уусгагч бодис
- Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал (ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй)
- Хортон шавьж, мэрэгчдийг устгах хор
- Мөнгөн ус агуулсан хаягдал (термометр, мөнгөн ус ашиглагдсан унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, энэ төрлийн гэрэлтүүлгийн хэрэгсэл)
- Электрон барааны хаягдал (РС, телевизор, гар утас)
- Аэрозол буюу шүршигч савтай бүтээгдэхүүний хаягдал (пропан цилиндр)
- Түлэгч, идэмхий бодисууд (цэвэрлэгээний бодис)
- Хөргөгч бодис агуулсан гэр ахуйн бараа
- Зарим тусгай батерей (литийн, никель кадмум, электрон цагны зай)
- Дарь
- Радио идэвхит хаягдал (утаа мэдрэгч)

1.6. “Барилгын хог хаягдал”-д: барилгын болон аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны явцад шууд болон шууд бусаар үүссэн цаашид ашиглах боломжгүй(хэрэгцээгүй) материалыг хамруулна. Үүнд:

- Тоосго
- Бетон,
- Тусгаарлагч болон дулаалгын материал
- Цахилгаан монтаж
- Хаягдал плита
- Ханын цаас
- Суурийн шороо

- Огтолсон мод, чулуу зэрэг барилгынбэлтгэл ажлын явцад үүссэн хог хаягдал багтаана.

1.7. “Эмнэлэгийн хог хаягдал”-д: Эрүүлийг хамгаалах үйл ажиллагааны явцад үүссэн хог хаягдлыг хэлнэ. Үүнд:

- Хэрэглэгдсэн тариур
- Тариурын зүү,
- Дуслын систем,хэрэгсэл,
- Бохирдсон боолт
- Биеийн хэсэг,
- Оношлогооны дээж,
- Цус
- Химийн бодис
- Эм(хугацаа дууссан, сав баглаа боодол гэмтсэн),
- Эмнэлгийн багаж хэрэгсэл,
- Радиоидэвхит материалыг багтаана

ХОЁР. ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ,ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ

2.1. Хоёрдогч түүхий эд/дахивар/-ийг цуглуулах, худалдан авах

2.1.1. Хоёрдогч түүхий эдийгцуглуулах ажлыг сумын Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулсан этгээд хүлээн авна. Гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү журмын 1.3-т заасан түүхий эдийг худалдан авна. Гэрээнд цэгийн байршил, ажиллах цагийн хуваарийг тодорхой зааж өгнө. Мөн гал, усны аюулгүй байдлыг хангах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах талаар гэрээнд тодорхой зааж өгнө. Орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар мөн тодорхой зааж өгнө.

2.1.2. Хоёрдогч түүхий эдийг худалдан авахдаа цэг байгуулах замаар болон явуулын машинаар үйлчилгээг зохион байгуулна.

2.1.3. Хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгийг орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахуйц газар байгуулж үл болно.

2.1.4. Гэр хороололд хоёрдогч түүхий эд худалдаж авах цэгийг гудамжны эхэнд болон төгсгөлд гал, усны аюулгүй газарт, айл өрх, хашаанаас зайдуу байршилд байгуулна.

Харин орон сууцны хороололд хоёрдогч түүхий эд цуглуулах явуулын машины үйлчилгээг нийтэд хүртээмжтэй болгоно.

2.1.5. Энэхүү хоёрдогч түүхий эд худалдаж авах цэгн өөр зүйл худалдан авах, худалдах эрх үүрэг эдлэхгүй.

2.1.6. Хоёрдогч түүхий эд худалдаж авах цэгийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтынбайгууллага, тухайн сумын ЗДТГ, багийн Засаг дарга хяналт тавина.

2.1.7. Мэргэжлийн хяналтын байгууллагаас тухайн хоёрдогч түүхий эд худалдаж авах цэгийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд үйл ажиллагааг нь зогсооно.

2.1.8. Хог хаягдлыг цуглуулах худалдан авахад шаардагдах бүх зардлыг энэ үйлчилгээг явуулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд хариуцна.

2.1.9.Хоёрдогч түүхий эд худалдаж авах цэг болон явуулын машинт үйлчилгээ нь энэхүүжурмын 1.2-д зааснаас бусад хог хаягдлыг хүлээн авахыг хориглоно.

2.1.10.Цуглуулсан хог хаягдлын нэр төрөл, тоо хэмжээг тухайн иргэн, аж ахуйн нэгж сумынЗДТГ-т хагас, бүтэн жилээр гаргажөгнө.

2.2. Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах

2.2.1. Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах иргэн, аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэсэн байна.

2.2.2. Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулахдаа байгальд ээлтэй үйлдвэрлэл,үйлчилгээг нэвтрүүлж ажиллана.

2.2.3. Ажилчиддаа хог хаягдлын талаар сургалт хийх, мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл авах

2.2.4. Хоёрдогч түүхий эд дахин боловсруулах үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын байгууллага, тухайн сумын ЗДТГ, багийн Засаг дарга хяналт тавина.

2.2.5. Мэргэжлийн хяналтын байгууллагаас тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд үйл ажиллагааг нь зогсооно.

2.2.6. Хоёрдогч түүхий эд дахин боловсруулахдаа энэ журмын 1.3-т заасан түүхий эдийг дахин боловсруулж, дахин ашиглана.

2.2.7. Дахин боловсруулсанхоёрдогч түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг тухайн иргэн, аж ахуйн нэгж сумын ЗДТГ-т хагас, бүтэн жилээр гаргаж өгнө.

2.3. Бусад хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх

2.3.1. Сумын Засаг дарга хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ хийнэ.

2.3.2. Гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, байгууллага хог хаягдлын цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг холбогдох стандартад нийцүүлэн явуулах.

2.3.3. Айл өрхийн хог хаягдлыг баталсан графикийн дагуу тогтмол хугацаанд тээвэрлэнэ.

2.3.4. Аж ахуйн нэгж байгууллагын хогийг гэрээний дагуу тогтсон хугацаанд мөн дуудлагаар ачиж цуглуулан, хогийн төвлөрсөн цэгт хүргэнэ.

2.3.5. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхдээ хүрээлэн буй орчин, хөрсийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авна.

2.4. Хог хаягдлыг устгах

2.4.1. Эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэж, байгальд халгүй аргаар булж устгана.

2.4.2. Эмнэлгийн тусгай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ариутгаж, халдваргүйтгэсэн тохиолдолд хогийн төвлөрсөн цэгт хүлээн авч, тусгайлан бэлдсэн цэгт (байгууламж) хаяна.

2.4.3. Барилгын хог хаягдалыг хогийн цэгт тогтоосон талбайд хаяна.

2.4.4. Аюултай хог хаягдлыг зориулалтын тусгай ангиллын хогийн цэгт хаяж, дарж булна.

ГУРАВ: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

3.1. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:

3.1.1. Хууль журмыг хэрэгжүүлэхэд нь сумдын ЗДТГ болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.

3.1.2. Хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд нь сумдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах

3.1.3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавих, үр дүнг тооцох

3.2. Сумын Засаг даргын хүлээх үүрэг:

3.2.1. Нутаг дэвсгэрийнхээ албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх өдөр, хуваарийг батална.

3.2.2. Ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулна. Гэрээ байгуулан үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавин ажиллана.

3.2.3. Нутаг дэвсгэрийн айл, өрх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хог хаягдлыг ангилан ялгаж хаях талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.2.4. Нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг ангилан ялгаж хаях, цуглуулах, устгах үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг сумын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

3.2.5. Анхан шатанд ахуйн хог хаягдлыг ангилан ялгасан айл өрх, байгууллага, аж ахуйн нэгжийг урамшуулах, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.2.6. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд хог хаягдлыг ангилан хаях, хадгалах саваар хангах, тэдгээрийг цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх

3.3. Багийн Засаг даргын хүлээх үүрэг:

3.3.1. Сумын Засаг даргын баталсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн дагуу баг хорооны нутаг дэвсгэрт ангилсан хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх графикийг гаргаж мөрдүүлнэ.

3.3.2. Нутаг дэвсгэрийн айл, өрх, иргэд, байгууллага, албан газар, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг энэхүү журамд заасны дагуу ангилан ялгуулах бөгөөд тэдгээрийн үйлажиллагаанд тогтмол хяналт тавина.

3.3.3. Багийн оршин суугчид болон байгууллага, аж ахуйн нэгж, СӨХ-ыг хамруулан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.3.4. Ангилсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын хог тээвэрлэлтийн график, хугацаа, давтамжинд хяналт тавьж хамтран ажиллана.

3.3.5. Хоёрдогч түүхий эд худалдан авч буй цэгийн үйл ажиллагаанд хяналт тавина

3.4. СӨХ-ны хүлээх үүрэг:

3.4.1. Харьяалж буй орон сууцныхаа оршин суугчид, хог хаягдлыг ангилан ялгаж хаях болон ангилсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн талаар мэдээлэл өгч, сургалт сурталчилгааг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.

3.4.2. Ангилсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлнэ.

3.5. Айл өрх, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг:

3.5.1. Хог хаягдлыг цуглуулахдаа орон сууцны хороолол, гэр хороолол, байгууллага аж ахуйн нэгж гэж 3 төрлөөр ангилна. Үүнд:

3.5.1.1. **Орон сууцны хороолол:** орон сууцны айл өрх, дахин ашиглах боломжтой хог хаягдлаа байр, орцыг хариуцан ажилладаг жижүүрт эсвэл тухайн хоёрдогч түүхий эдийг цуглуулагч иргэн, аж ахуйн нэгж, харин бусад ахуйн хог хаягдлаа байр, орцнуудын нэгдсэн хогийн цэг, нэгдсэн цэггүй тохиолдолд тогтсон хугацаанд шууд хог тээврийн машинд, ахуйн аюултай, эмнэлгийн хаягдлыг тусгай зориулалтын сав, хүлээн авах тусгай цэгт батлагдсан өдөр, хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

3.5.1.2. **Гэр хороолол:** Дахин ашиглах боломжтой хог хаягдал, бусад хог хаягдал гэж 2 төрлөөр зориулалтын саванд хадгалах бөгөөд (ахуйн аюултай, эмнэлгийн хаягдлыг тусгай зориулалтын сав, хүлээн авах тусгай цэгт) батлагдсан өдөр, хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагад хүлээлгэн өгнө.

3.5.1.3. **Байгууллага аж ахуйн нэгж:** Дахин ашиглах боломжтой болон бусад хог хаягдал гэж 2 төрлөөр зориулалтын саванд хадгалах бөгөөд эмнэлэгийн болон аюултай, барилгын хог хаягдлыг тусгай зориулалтын машин техникт зааврын дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагад батлагдсан өдөр, хуваарийн дагуу хүлээлгэж өгнө.

3.6. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг:

3.6.1. Сумын Засаг даргын баталсан өдөр, хуваарийн дагуу дахин ашиглах болон бусад хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

3.6.2. Үйл ажиллагаандаа холбогдох чиглэлээр гарсан хууль дүрэм, журам, Монгол Улсын стандартыг хэрэгжүүлж ажиллах

3.6.3 Иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулахгүй, замын хөдөлгөөнд аюултай байдал бий болгохгүй, хүрээлэн буй орчинг сүйтгэх эсвэл бусад хүмүүсийн амгалан тайван

байдлыг алдагдуулахгүй байх байдлаар хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхүйлчилгээг үзүүлэх

3.6.4 Тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг улирал бүр сумын ЗДТГ-т гаргаж өгнө.

ДӨРӨВ: ХОРИГЛОХ ЗҮЙЛС

4.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгалгүй хаях

4.2. Ангилсан болон бусад хог хаягдлыг зориулалтын хадгалах саванд байх тохиолдолд шатаах, гал гаргах, ухаж тараах

4.3. Ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагаас өөр этгээд цуглуулах, тээвэрлэх болон ямарваа нэгэн үйл ажиллагаа явуулах

4.4. Хог хаягдлыг нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан, шуудуунд ил задгай хаях

4.5. Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь журамд заасан хоёрдогч түүхий эдээс бусад түүхий эдийг ашиглах

4.6. Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг цуглуулах зорилгоор хог хаягдлыг хүлээн авах цэгийг тусгайлан тогтоосон тохиолдолд хог хаягдал эзэмшигч нь хогоо зориулалтын бус газар, ил задгай хаяхыг хориглоно.

ТАВ: ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг “Хог хаягдлын тухай” хуулийн 23.1.3 -ын дагуу хууль тогтоомж журам, дүрмийг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

5.2. Энэхүү журмын биелэлтэд эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга хяналт тавина.

ЗУРГАА: УРАМШУУЛАЛ

6.1. Хог хаягдлыг анхан шатанд ангилан ялгаж хэвшсэн, хог хаягдлыг дахин ашиглах шинэ санал санаачилгыг гаргасан, мөн хорёрдогч түүхий эдийг цуглуулах, тээвэрлэх,

дахин боловсруулахад бусдад үлгэр дуурайл болсон айл өрх, иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, олон нийтэд сурталчлах, бүх талаар дэмжиж ажиллах

6.2. Дээрхи дэмжлэг, урамшууллын арга хэмжээг тухайн иргэн аж ахуйн нэгжийн хүсэлт, багийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.